**БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР,**

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР**

ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР



**ЦЭРГИЙН СУРГАЛТЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар
(цаашид "Талууд" гэх)

1999 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Цэргийн салбар дахь хамтын
ажиллагааны талаарх Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар, Монгол Улсын
Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг үндэслэж,

Талуудын хооронд нөхөрсөг харилцаа болон цэргийн салбар дахь хамтын
ажиллагааг сайжруулах эрмэлзлэлийг онцолж,

Дор дурдсанаар харилцан тохиролцов. Үүнд:

**1 дүгээр зүйл
ЗОРИЛГО**

Энэхүү хэлэлцээр нь цэргийн сургалтын салбарт Талуудын хооронд хамтран
ажиллах механизмыг бий болгоход оршино.


**2 дугаар зүйл
ХАМРАХ ХҮРЭЭ**

Энэхүү хэлэлцээрийн заалтууд нь хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн дагуу нөгөө
Талын цэргийн байгууламж, цэргийн сургалтын байгууллага болон анги салбарт
сургалтад хамрагдахаар зөвшөөрөгдсөн, эсхүл хамтын үйл ажиллагаа болон
сургалтын явцад хамрагдаж буй Талуудын аль нэгний Зэвсэгт хүчний офицер,
ахлагч, тусгай мэргэшлийн түрүүч, гэрээт цэргийн алба хаагч, хугацаат цэргийн алба
хаагч, цэргийн сургуулийн сонсогч, энгийн ажилтанд болон тэдний гэр бүлийн
 гишүүдэд хамаарна.

**3 дугаар зүйл
НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

Энэхүү хэлэлцээрт заасан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1. "Хэлэлцээр" гэж Талуудын хооронд байгуулсан Цэргийн сургалтын хамтын
ажиллагааны хэлэлцээрийг хэлнэ,
2. "Илгээгч улс" гэж энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор хүлээн авагч улс руу
бие бүрэлдэхүүн, материал, тоног төхөөрөмжийг илгээж буй улсыг,
3. "Хүлээн авагч улс" гэж энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн нутаг
дэвсгэртээ илгээгч улсын бие бүрэлдэхүүн, материал, тоног төхөөрөмжийг хүлээн
авч байгаа улсыг,



4. "Эрх бүхий байгууллага" гэж энэхүү хэлэлцээрийн хэрэгжилттэй холбоотой дараах Талуудын эрх бүхий байгууллагыг:

1. Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар: Бүгд Найрамдах Турк Улсын Зэвсэгт Хүчний Ерөнхий Штаб

2. Монгол Улсын Засгийн газар: Монгол Улсын Батлан хамгаалах яам

5. "Зочин цэргийн алба хаагч" гэж суралцагч, сургагч, багш зааварлагч, зөвлөгч, ажиглагч зэрэг энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа Талуудын цэргийн болон энгийн албан хаагчийг,

6. "Гэр бүлийн гишүүн" гэж энэхүү Хэлэлцээрийн хамрах хүрээнд зочин цэргийн алба хаагч холбогдох үндэсний хууль тогтоомжийн дагуу түүнийг дагалдаж яваа эхнэр/нөхөр, хүүхдийг,

7. "Захирагч" гэж цэргийн удирдах төв байр, цэргийн бааз, цэргийн анги салбарыг захирч байгаа, өөрт захирагдахаар илгээсэн цэргийн алба хаагчийн үйл ажиллагааны төлөө үүрэг хүлээдэг этгээдийг,

8. "Цэргийн ахлах албан тушаалтан" гэж энэхүү хэлэлцээрийн хамрах хүрээнд илгээсэн цэргийн/иргэний багийн үйл ажиллагаанд хяналт тавихаар эрх авсан цэргийн алба хаагчдаас хамгийн ахмад/ахлах гишүүн ба илгээгч улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу томилогдсон этгээдийг,

9. "Уригдсан сонсогч" гэж илгээгч улсаас офицер, ахлагчийн хувиар цэргийн академи, анагаах ухааны цэргийн факультет, цэргийн ахлах сургууль, ахлагчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн дээд сургуульд суралцуулахаар томилогдсон офицер, ахлагчийн статус хараахан аваагүй байгаа ажилтанг,

10. "Энгийн ажилтан" гэж Талуудын зэвсэгт хүчинд байнгын ажлын байранд цэргийн болон цэргийн бус ажил үүрэг гүйцэтгэж буй этгээдийг,

11. "Харилцан солилцоо" гэж хоёр улсын зөвшөөрлөөр тодорхойлогдон, тодорхой хугацаанд харилцан гүйцэтгэх үйл ажиллагааг,

12. "Цэргийн солилцооны алба хаагч" гэж энэхүү хэлэлцээрийн хүрээн дэх солилцооны үйл ажиллагаанд зориулан Турк болон Монгол Улсад байрлаж байгаа этгээдийг,

13. "Дагалдах офицер" гэж уригдсан цэргийн алба хаагчид туслах үүрэг бүхий албан ёсны төлөөлөгчөөр ажиллах хүлээн авагч улсын эрх бүхий ажилтанг хэлнэ.


14. "Нууц мэдээлэл" гэж Бүгд Найрамдах Турк Улс болон Монгол Улсын олж авсан мэдээлэл, эдгээр Талуудын аль нэг талын эрх мэдэл буюу хяналтанд байгаа үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолын дагуу хамгаалагдсан байх ёстой, нууцлалын зэрэглэлийн тэмдэглэгээтэй албан ёсны мэдээллийг хэлнэ. Энэхүү мэдээлэл нь бичгээр гаргасан, харааны, соронзон, техник болон технологийн хэлбэрээр байж болно.

4 дүгээр зүйл

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САЛБАР

Талууд дараах чиглэлээр сургалтын хамтын үйл ажиллагаа явуулна:


1. Команд штабын коллеж, цэргийн анагаах ухааны академи болон цэргийн зураг зүйн сургуулийн сургалт,



2. Цэргийн дунд боловсролын сургуулийн сургалт(цэргийн ерөнхий боловсролын сургууль, цэргийн академи, цэргийн эрүүл мэндийн сургууль, ахлагчийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн дээд сургууль) болон салбар сургууль,
3. Цэргийн цагдаагийн сургуулийн сургалт,
4. Сургалтын төв дэх мэргэжлийн өмнөх сургалт, дамжаа,
5. Их сургууль дахь магистр болон докторын сургалт,
6. Их сургууль, Удирдах төв байр, салбар нэгж дэх ажлын байран дээрх сургалт,
7. Их сургууль, Удирдах төв байр, салбар нэгжүүдэд зөвлөхөөр томилох,
8. Их сургууль, Удирдах төв байр, салбар нэгжүүд дэх айлчлал,
9. Боловсрол, сургалтын байгууллага хоорондын багш/оюутан харилцан болон нэг талын солилцоо, зөвлөгөөн,
10. Төлөөлөгч солилцоо,
11. Цэргийн дасгал сургуульд ажиглагчаар оролцох,
12. Хамтарсан сургуульд оролцох,
13. Сургалт сайжруулахад зориулсан мэдээллийн харилцан солилцоо,
14. Цэргийн түүх, цэргийн архив, цэргийн музей судлалын салбар дахь хамтын ажиллагаа,
15. Цэргийн анагаах ухаан, эрүүл мэндийн үйлчилгээний салбар дахь хамтын ажиллагаа,
16. Цэргийн алба хаагчийн эрх зүйн сургалт, мэдээллийн солилцоо,
17. Цэргийн ар талын сургалтын салбар дахь хамтын ажиллагаа,
18. Энхийг дэмжих болон хүмүүнлэгийн тусламжийн чиглэлээрх хамтын ажиллагаа,
19. Бие бүрэлдэхүүн/ажилтан солилцох,
20. Турк болон Монгол хэлний дамжаанд бие бүрэлдэхүүн сургах,
21. Зураг зүй болон усны түвшин судлалын чиглээрх хамтын ажиллагаа,
22. Нийгэм, спорт, соёлын чиглэлээрх үйл ажиллагаа,
23. Боловсон хүчин, хүний нөөцийн төлөвлөлт, хүний нөөцийн хангалт сургалт, хөдөлмөр эрхлэлт, ажилтны эрхийн чиглэлээрх сургалт, мэдээлэл солилцоо.

5 дугаар зүйл ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

1. Сургалтыг хүлээн авагч улсын шалгуурын дагуу явуулна.
2. Энэхүү хэлэлцээрийн дагуу илгээгч улс нь сургалтын хүсэлтээ өмнөх оны 3 дугаар сард, хамгийн сүүлдээ сургалт, дамжаа эхлэхээс өмнө хүлээн авагч улсад хүргүүлнэ. Хүсэлтийг хүлээн авснаас хойш, хүлээн авагч улс нь өөрийн боломжийг судалж үзээд илгээгч улсад хариу мэдэгдэнэ.
3. Онцгой тохиолдолд, Талууд нь богино хугацааны сургалт болон энэхүү гэрээнд тусгайлан заасан бусад сургалтын талаарх хүсэлтээ албан ёсоор бичгээр мэдэгдэнэ. Энэхүү нэмэлт хүсэлт нь аль болох Талуудын хооронд зөвшилцсөний үндсэн дээр төлөвлөгөөнд орж болно.



4. Сургалтыг хүлээн авагч улсын хэлээр зохион байгуулах урьдчилсан нөхцөлтэй. Хэрэв илгээгч улсын хүсэлт болон хүлээн авагч улс тохиромжтой гэж үзсэн тохиолдолд 3 сараас доош хугацааны сургалтыг хэлмэрчээр дамжуулан явуулж болно. Сургалтыг хэлмэрчээр дамжуулан явуулж байгаа тохиолдолд, илгээгч улс нь сургалтад илгээж буй бие бүрэлдэхүүнтэй хамт хангалттай тооны цэргийн орчуулагчийг томилно. Илгээгч улс нь орчуулга/хэлмэрчийн зардлыг гаргана.

5. Илгээгч улс нь шаардлагатай зохицуулалтыг хийх боломжийг олгохын тулд сургалт эхлэхээс 45 (дөчин тав)-аас доошгүй хоногийн өмнө сургалтад оролцох талаарх эцсийн шийдвэр, сургалтад оролцогчдын тоо, нислэгийн болон бусад мэдээллийг хүлээн авагч улсад мэдээлнэ. Хугацаандаа амжиж хүсэлтээ ирүүлээгүй тохиолдолд хүлээн авагч улс сургалтыг хойшлуулах, эсхүл бүрмөсөн цуцална.

6. Хамтын ажиллагаа нь Талуудын хууль эрх зүйн зохицуулалтыг хүндэтгэх, харилцан адил байх зарчмын үндсэн дээр хийгдэнэ.

7. Сургалтын хүсэлтийг Хүлээн авагч улсын эрүүл мэндийн журмын хүрээнд зохицуулна.

6 дугаар зүйл СУРГАЛТЫН НӨХЦӨЛ

1. Уригдсан цэргийн алба хаагч болон сонсогчийн сургалт нь сургалт явагдаж буй цэргийн байгууллага, анги салбарын хөтөлбөрийн дагуу явагдана. Хэрэв хичээлийн сэдэв нь үндэсний аюулгүй байдлын асуудлыг хамарвал хязгаарлалт тавьж болно.

2. Хүлээн авагч улс нь сургалтын хугацааны туршид уригдсан цэргийн алба хаагч болон сонсогчийг хангах мөн сургалтын төгсгөлд Хүлээн авагч улсад буцааж өгөх тоног төхөөрөмж болон сургалтын материалыг зааж болно.

3. Илгээгч нь улс нь Хүлээн авагч улсын тодорхойлсон шаардлагын дагуу сургалтад хамрагдах алба хаагчдыг сонгоно. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас тогтоосон шаардлага хангаагүй алба хаагчийг сургалтад хүлээн авахгүй.

4. Хүлээн авагч улс нь шалгалтын төрөл болон сургалттай холбогдсон зохицуулалтыг хийнэ.

5. Протокол, эсхүл техникийн/захиргааны зохион байгуулалтыг энэхүү хэлэлцээрт тулгуурлан байгуулж болно. Эдгээр протокол, эсхүл техникийн/захиргааны зохион байгуулалт нь дараах зүйлсийг багтааж болно. Үүнд:



a. Сургалтын сэдэв,

b. Сургалт болох газар

c. Сургалт явуулах хэл, сургалтын хугацаа болон хөдөөтэй

d. Сургалтын туршид цэргийн алба хаагчийн эрх зүйн

e. Сургалтын эхлэх болон дуусгавар болох хугацаа, сургалтад оролцогчдын тоо



- f. Сургалтад оролцогчид шаардагдах боловсролын зэрэг
- g. Сургалтын хугацааны туршид цэргийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ
- h. Алдагдал болон нөхөн төлбөрийг олгох арга
- i. Сургалтын талаарх төлбөрийн нөхцөл болон журам
- j. Яаралтай тусламжийн үзлэг, анхны тусламж болон яаралтай шүдний тусламжаас бусад үзүүлсэн эмнэлэгийн үйлчилгээ, үзлэг, эмчилгээ, шүдний тусламж үйлчилгээний нөхөн төлбөр олгох арга
- k. Хоол, байр болон тээврийн талаарх зохицуулалт
- l. Сургалттай холбоотой бусад зохицуулалт

6. Заасан сургалтын хөтөлбөрийг дүүргэж, сургалт дамжааны нөхцөлийн дагуу авсан шалгалтыг амжилттай өгч, диплом/төсөл зэрэг эрдмийн бүтээлээ амжилттай бэлтгэж, хамгаалсан сургалт, дамжаанд оролцохоор илгээсэн алба хаагчид, хэрэгцээтэй бол тэдгээр нь сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн болон сургалтын дагуу эрдмийн зэрэг зэргийг илтгэсэн төгсөлтийн гэрчилгээ (диплом, гэрчилгээ гэх мэт)-г олгоно. Илгээгч улсын хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагаас олгосон төгсөлтийн гэрчилгээ (диплом, сертификат) нь дүйцсэнг батална.


7 дугаар зүйл АЛБА ХААГЧ СОЛИЛЦООНЫ ЕРӨНХИЙ АСУУДАЛ, ЭРХ ҮҮРЭГ БОЛОН НӨХЦӨЛ

Хэрэв Талууд алба хаагчид солилцох талаар тохиролцоонд хүрсэн бол дараах үүргийг гүйцэтгэнэ.

1. Мэргэшсэн алба хаагчийн урт хугацааны томилолт нь харилцан адил байх зарчмын үндсэн дээр хэлний сургалт, мэдээлэл болон туршлага солилцох харилцан сонирхлыг хангах болон нэгдсэн соёл, ойлголцлыг бий болгох арга замаар хийгдэнэ.

2. Томилогдох алба хаагчдын тоо, болзол (шаардлага)-ын талаарх нэмэлт/хасалт, солилцооны асуудал, эсхүл одоогийн солилцооны үйл ажиллагаа нь хоёр орны хооронд зохион байгуулах албан ёсны уулзалт болон дээд хэмжээний айлчлалын үеэр зөвшилцлийн замаар хийгдсэн тохиролцоонд үндэслэн тодорхойлогдоно. Хүлээн авагч улс нь цэргийн солилцооны алба хаагчдыг тэдний мэргэжил, туршлага шаардлагатай байгаа газруудад илгээгч улсын бичгээр гаргасан зөвшөөрлийн дараа томилно. Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол,

- а) Төрөлх хэлний багш нар хэлний сургуульд
- б) Эрдэм шинжилгээний ажилтан нь цэргийн сургууль болон дайны коллежид
- в) Цэргийн хэрэгт шинжээч алба хаагчид нь холбогдох салбар сургуульд
- д) Цэргийн багийн захирагч (батальон захирагч, батальоны захирагчийн орлогч, салаа/ротын захирагч, салаа/ротын ахлагч зэрэг) цэргийн сургууль болон бусад тохиролцсон цэргийн анги салбарт
- е) Штабын офицерууд нь хүчний штаб эсхүл зөвшөөрөгдсөн төв штабт, тохиролцсон бусад анги салбарт тус тус алба хаана.



3. Энэ хүрээнд уригдсан алба хаагчийн томилгоо нь 6 сар байна. Хэрэв шаардлагатай бол үүний үргэлжлэх хугацаа болон нийт хугацааг солилцооны онцлог шинжийн дагуу хоёр улсын бичгээр гаргасан зөвшөөрлийн дагуу өөрчилж болно.

4. Талууд алба хаагчдын солилцоог цаашид шаардлагагүй эсвэл тэдний харилцан ашиг сонирхолд үйлчлэхгүй байна гэж үзвэл холбогдох өөрчлөлт, эсхүл солилцооны сэдэв болон хугацаанд өөрчлөлт оруулж болно.

5. Талууд өөрөөр тохиролцоогүй бол солилцооны цэргийн алба хаагчийг сургалтын төгсгөлд шаардлага хангасан өөр хүнээр сольж болно.

6. Илгээгч улс нь дараах шалгуурын дагуу солилцооны хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдыг сонгож, томилно:

- а) Шаардлагатай боловсрол болон мэргэжлийн туршлагатай байх
- б) Илгээгч улсын цэргийн албан тушаалд ажиллаж байгаа алба хаагч байх
- в) Хүлээн авагч улсын үндэсний бодлого, үнэт зүйл, соёл, амьдралын хэв маягийн дагуу биеэ авч явах чадвартай байх ёстой.

7. Илгээгч улс нь дээрх шаардлагыг хангасан солилцооны цэргийн алба хаагчдыг бие даан сонгох эрхтэй. Солилцооны цэргийн алба хаагч нь заасан мэргэжилгүй буюу мэргэжлийн бус, сахилга батын доголдол, онолын хангалтгүй мэдлэг, чадваргүй байдал, эрүүл мэндийн болон бие махбодийн шалтгаанаар эсвэл тэдний өөрсдийн хүслээр эсвэл тодорхой бус шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон зэрэг шалтгааны улмаас сургалтаа орхих тохиолдолд илгээгч улс нь ямар нэгэн зөвтгөх шалтгааны талаар хүсэлт гаргалгүйгээр алба хаагчаа эгүүлэн татаж өөр хүн томилно. Энэ тохиолдолд, хүлээн авагч улс нь солилцооны цэргийн алба хаагчийн орны хүний талаар цэргийн атташегийн албаар дамжуулан илгээгч улсад уламжилна.

8. Илгээгч улс нь солилцооны сургалт эхлэхээс өмнө бэлтгэл ажил хангахад зориулан солилцооны цэргийн алба хаагч нь шаардлагатай нөхцөлүүд, мэргэшлийн шаардлагыг хангасан болохыг түүнчлэн цэргийн цол, мэргэжлийн бүртгэлийн дугаар, төрсөн он сар, өдөр, намтар (боловсролын түвшин), цусны бүлэг зэрэг мэдээллийг үзүүлсэн албан ёсоор батлагдсан баримт/захидлыг хүлээн авагч улсад илгээнэ.

9. Солилцооны цэргийн алба хаагчид ямар нэгэн тушаал болон хяналтын үүрэг гүйцэтгэхгүй. Солилцооны цэргийн алба хаагчид зөвхөн сургалтын үйл ажиллагаатай холбогдсон үүрэг гүйцэтгэнэ. Солилцооны цэргийн алба хаагч нь хичээлийн хөтөлбөр бэлтгэхгүй, үнэлгээ хийхгүй, шалгалт авахгүй. Хэдийгээр, тэд хичээлийн оролцооны талаар үзэл бодлоо илэрхийлж, хичээлийн хөтөлбөрийг сайжруулахад зориулан санал гаргаж болно.

10. Солилцооны цэргийн алба хаагч болон хүлээн авагч улсын цэргийн алба хаагч хоорондын харилцаа цэргийн ёс зүйн дүрмээр тогтоогддог. Хэрэв шаардлагатай бол Солилцооны цэргийн алба хаагч нь сургалтын хөтөлбөрийн захирагчийн үйл ажиллагаа болон бусад асуудлаар Хөтөч Офицерын зөвлөгөө авна.



11. Солилцооны цэргийн алба хаагч нь сургалтын үед хийгдэх үйл ажиллагааны талаар өөрийн улсаас гаргасан албан ёсны ном сурах бичиг, сонин сэтгүүл, мултимедиа зэргийг авчирч болно. Эдгээр материалыг хөтөч офицероор дамжуулан нэгж тарааж өгнө.

12. Солилцооны цэргийн алба хаагч нь лекц, сургалт болон бусад уулзалтын үеэр сургалтын оролцогчид болон суралцагчидтай бүх нийтээр гэмт хэрэгт тооцогддог, хууль зүйн үр дагавар дагуулсан асуудлаар ярилцах ёсгүй.

13. Солилцооны цэргийн алба хаагч нь өдөр тутмын болон долоо хоног тутмын ажлын цагийг дагаж мөрдөнө. Гэсэн хэдий ч, солилцооны цэргийн алба хаагчийн эрх бүхий байгууллагын бичгээр гаргасан зөвшөөрлөөр өөрсдийн улс орны үндэсний болон шашны өдрүүдэд чөлөөтэйд тооцогдоно.

14. Солилцооны цэргийн алба хаагч нь хүлээн авагч улсын анги болон байгууллагад өөрийн орны дүрэмт хувцсыг, сургалт болон бусад үйл ажиллагааны туршид хүлээн авагч улсаас хангасан дүрэмт хувцас, бусад үйл ажиллагааны үед энгийн хувцас өмсөнө.

15. Хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу зардлаа өөрсдөө хариуцсан нөхцөлд солилцооны цэргийн алба хаагч нь гэр бүлийн гишүүнээ авчрах эрхтэй.


16. Энхийг сахиулах ажиллагаанд солилцооны цэргийн алба хаагч нь аливаа цэргийн ажиллагаа, дасгал болон сургуульд оролцохгүй.

17. Хэрэв Талууд өөрөөр тохиролцоогүй бол Солилцооны цэргийн алба хаагч нь суралцаж байгаа цэргийн анги, нэгж, байрлаж байгаа цэргийн хүрээний хил хязгаар дотор байрлана.

8 дугаар зүйл НУУЦ МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТ

1. Талууд нь үндэсний хууль тогтоомжийн дагуу, энэхүү хэлэлцээрийн хэрэгжилт болон хамтарсан үйл ажиллагааны хамрах хүрээнд солилцох баримт, материал болон тоног төхөөрөмжтэй холбогдсон бүх мэдээллийг хамгаална. Солилцсон мэдээллийн нууцын зэрэглэлийг өөрчилж болохгүй. Энэ хүрээнд, Талууд нь нууцын ижил зэрэглэлтэй өөрсдийн мэдээллийг хамгаалахад хэрэглэгддэг арга хэмжээг авна. Солилцсон мэдээлэлд дараах нууцын зэрэглэлийн ангилал, хугацааны тохирохыг өгнө. Онц чухал-маш нууц, нууц, албан хэрэгцээнд, хязгаарлагдсан болон нууц биш.

2. Талууд аль аль нь энэхүү Хэлэлцээрийн хамрах хүрээн дэх хамтын ажиллагааны хэрэгжилтийн туршид солилцсон аливаа төрлийн мэдээлэл, олж авсан зэвсэг, материал тоног төхөөрөмжийг тэднийг хөгжүүлэхтэй холбогдсон техникийн баримт бичиг, эсхүл бусад мэдээлэл, баримт бичиг зэргийг гэрээний гадна талд задруулах, худалдах, дамжуулах, хуваалцахыг хориглоно.



3. Талууд нь зөвхөн мэдэх шаардлагатай, нууцын баталгаатай албан хаагчид нууц мэдээлэл болон материалд нэвтрэх эрхтэй байх баталгааг хангана.

4. Энэхүү хэлэлцээрийн зүйл, заалтыг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг Талуудын нэг нь нөгөө Талын болон Гуравдагч талын ашиг сонирхлын эсрэг хэрэглэхийг хориглоно.

5. Энэхүү хэлэлцээр дуусгавар болсны дараа Талууд нь нууц мэдээллийг хамгаалах болон тэдгээрийг задруулахаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй хэвээр байх болно.

6. Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд солилцсон мэдээлэл санаандгүйгээр ил болсон, задарсан тохиолдолд, үүнийг илрүүлсэн тал нь нөгөө талдаа нөхцөл байдлын талаар нэн даруй мэдээлнэ.

7. Талууд энэхүү хэлэлцээрийн хамтын ажиллагааны хүрээнд олж авсан мэдээллийг зөвхөн энэхүү хэлэлцээрийн зорилготой нийцүүлэн хэрэглэнэ.

9 дүгээр зүйл БУСАД ОЛОН УЛСЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ДАГАЖ МӨРДӨХ

1. Энэхүү Хэлэлцээрийн заалтууд нь Талуудын аль алины байгуулсан бусад олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэгт нөлөөлөх ёсгүй.

2. Энэхүү хэлэлцээрт заагаагүй асуудлаар, Цэргийн салбар дахь хамтын ажиллагааны хэлэлцээрийг суурь болгон авч үзнэ.

10 дугаар зүйл ТУСГАЙ АСУУДАЛ

1. Зочин цэргийн алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүд, түүнчлэн зочин сонсогч нь суралцах хугацаандаа гуравдагч улс оронтой аливаа хэлбэрийн зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй байх болон хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт үлдэх, хүлээн авагч улсын ашиг сонирхол болон дотоод аюулгүй байдалд хохирол учруулах үйл ажиллагаанд оролцохгүй байх үүрэгтэй. Зочин цэргийн алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүд, түүнчлэн зочин сонсогч нь хүлээн авагч улсад байрлах хугацааны туршид энэхүү хэлэлцээрт зааснаас бусад аливаа үйл ажиллагаанд оролцохгүй.

2. Амжилтгүй, сахилга батгүй, эрүүл мэндийн дорой байдал зэрэг шалтгааны улмаас сургалтаа үргэлжлүүлэх боломжгүй зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогчийн нөхцөл байдал нь холбогдох албан тушаалтан, сургуулийн удирдлага, эсвэл цэргийн коллеж болон Факультетийн деканы газрын шийдвэрээр тодорхойлогдоно. Тусгаарлах үйл ажиллагаа болон сургалт боловсролыг дуусгавар болгосон тухай эрх бүхий байгууллагын бэлтгэлөөр гаргах арга хэмжээг авна.



3. Илгээгч улс ньшаардлагатай гэж үзвэл, ямар нэгэн шалтгаан заалгүйгээр ямар ч үед зочин цэргийн алба хаагч болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд мөн түүнчлэн зочин сонсогчийг эгүүлэн татаж авах эрх эдэлнэ. Хүлээн авагч улс нь илгээгч улсын аль болох богино хугацаанд буцаахад шаардлагатай зардлыг гаргана.

4. Дайн, зэвсэгт мөргөлдөөн, нийгмийн бослого болон олон улсын хямралт байдлын үед Хүлээн авагч улс нь Илгээгч улсад өөрийн бие бүрэлдэхүүнээ эгүүлэн татаж авах хүсэлт тавьж болно. Илгээгч улс нь тэр даруй энэхүү хүсэлтийг биелүүлнэ.

5. Зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогч хүлээн авагч улсын нутаг дэвсгэрийг ямар нэгэн шалтгаанаар орхин гарах үед өөрийн хувийн болон гэр бүлийн гишүүдийн өр төлбөрийг барагдуулна. Зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогчийн төлж барагдуулаагүй өр төлбөрт илгээгч улс нь шаардлагатай арга хэмжээг авна.

11 дүгээр зүйл ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

1. Шүүхийн харъяалал:

а. Зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүд, мөн түүнчлэн Зочин сонсогч нь Хүлээн авагч улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж, дүрэм журамд захирагдана.

б. Зочин цэргийн алба хаагч, Цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүд, мөн түүнчлэн Зочин сонсогчийн үйлдсэн дараах гэмт хэргүүд нь Илгээгч улсын хууль тогтоомжоор хариуцлага хүлээнэ.

1. Зөвхөн Илгээгч улсын эд хөрөнгө, аюулгүй байдал болон Зочин цэргийн алба хаагч, Цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүд, мөн түүнчлэн Зочин сонсогчийн эд хөрөнгө, хүний эсрэг үйлдсэн гэмт хэргүүд,


2. Зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч, мөн түүнчлэн зочин сонсогчийн сургалт, боловсролтой холбоотой гэмт хэргүүд, сургалт, боловсролын үйл ажиллагааны туршид тэдний санаатай үйлдэл, эс үйлдлээс үйлдэгдсэн гэмт хэргүүд,

с. Хүлээн авагч улсын хуулийг хэрэглэж байгаа тохиолдолд, шийтгэх тогтоолд нь Илгээгч улсын хууль тогтоомжид байдаггүй шийтгэл тусгагдсан бол, аль аль улсуудын хууль тогтоомжид оршдог, эсхүл зохимжтой гэж үзсэн аль нэг шийтгэлийг хүлээлгэнэ.

2. Сахилгын арга хэмжээ:

а. Зочин цэргийн алба хаагч, Цэргийн солилцооны алба хаагч болон Зочин сонсогч нь тухайн байрлаж буй цэрэг, штаб, агентлагуудын сахилгын дүрэм журмыг дагаж мөрдөнө.

б. Зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч болон зочин сонсогч нь сахилгын шийтгэлийг харгалзан үзэж илгээгч улсын хууль тогтоомжид захирагдана.



Илгээгч улс нь хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дэх зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч болон зочин сонсогчийн хувьд өөрийн онцгой сахилгын эрх мэдлээ хадгална. Гэсэн хэдий ч, хүлээн авагч улсын эрх бүхий цэргийн байгууллага нь тэдний командлалд байгаа зочин цэргийн алба хаагч, Цэргийн солилцооны алба хаагч болон зочин сонсогчид үүргийн дагуу хууль тогтоомжид нийцсэн тушаал өгч болно.

с. Талуудын эрх бүхий цэргийн байгууллага нь зөвхөн нэгж сургалтад хэрэглэгдэх сахилгын арга хэмжээний нөхцлийг тодорхойлох, сахилгын шийтгэлийг тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэх, маргааныг шийдвэрлэхтэй холбоотой комисс байгуулж болно. Комиссын шийдвэрийн тэмдэглэл хөтлөх ба Талууд заавал дагаж мөрдөхөөр хүлээн зөвшөөрнө. Сахилгын шийтгэлийг зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогч сургалтад хамрагдах газрын удирдах байгууллага, агентлагийн ахлах дээд тушаалтан эсвэл холбогдох улсын нөхцөл, журмын дагуу илгээгч улсын ахлах дээд албан тушаалтан нь өгнө.

3. Зочин цэргийн сонсогч, Цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүн мөн түүнчлэн Зочин сонсогч баривчлагдсан тохиолдолд Хүлээн авагч улс нь нөхцөл байдлын талаар Илгээгч улсад нэн даруй мэдэгдэнэ.

4. Зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүд, мөн түүнчлэн зочин сонсогч нь хүлээн авагч улсад мөрдөн байцаалт, шүүхэд дуудагдсан тохиолдолд, тэдгээр нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль зүйн хамгаалалт эдлэх эрхтэй ба энэ нь хүлээн авагч улсын иргэний эдлэх эрхээс бага байх ёсгүй.

5. Зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч болон зочин цэргийн сонсогч нь хүлээн авагч улсын хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд, тэдний үйл ажиллагааг дуусгавар болгоно.

6. Хүлээн авагч улсад гэмт хэрэгт тооцогддоггүй солилцооны алба хаагчдын үйлдэлд Илгээгч улсын ахлах албан тушаалтан нь холбогдох цэргийн алба болон сахилгын дүрмийн дагуу сахилгын арга хэмжээг хэрэгжүүлэх эрхтэй байна.

7. Зочин цэргийн алба хаагч, Цэргийн солилцооны алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүд болон Зочин сонсогч нь Хүлээн авагч улсад нэвтрэх, байрлах болон явах хугацааны туршид гааль, татвар болон бараа худалдан авах, худалдахад Хүлээн авагч улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

8. Энэхүү хэлэлцээрт тусгагдаагүй асуудлаар Цэргийн салбар дахь хамтын ажиллагааны хэлэлцээрийн заалтыг хэрэглэнэ.

12 дугаар зүйл САНХҮҮГИЙН АСУУДАЛ

1. Зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогчийн талаарх асуудал:



а. Хүлээн авагч улс нь Зочин цэргийн алба хаагч болон Зочин сонсогчийн хамрагдаж буй сургалт нь хариу төлбөртэй, төлбөргүй, эсвэл багасгасан төлбөртэй эсэх мөн байр, хоолны зардал төлөх эсэхийг шийдвэрлэнэ.

б. Хэрвээ төлбөр хийх шийдвэр гарвал, дараах нөхцлийн дагуу хийнэ:

(1) Зочин сонсогчийн хувьд:

(а) Хоол

(д) Байр

(с) Өдөр тутмын тэтгэмж (Хүлээн авагч улс нь нөхцөл болон хэмжээг тогтооно)

(д) Хувцас (Хүлээн авагч улсын түүнтэй адилтгах сонсогчид тогтоосон хуваарилалтын дагуу)

(2) Зочин цэргийн алба хаагчийн хувьд:

(а) Сар тутмын цалин (Хүлээн авагч улс нь сургалтад оролцогч офицер, ахлагчийн цолыг харгалзан нөхцөл, хэмжээг тогтооно)

(б) Хувцас (зөвхөн сургалт-боловсролын байгууллагад сургалтад хамрагдаж буй зочин цэргийн алба хаагч нь хүлээн авагч улсын түүнтэй адилтгах бие бүрэлдэхүүнд тогтоосон хуваарилалтын дагуу ашиглана)

с) Хэрвээ сургалт нь хариу төлбөртэй бол хүлээн авагч улс нь дараах шаардлагыг үнэ төлбөргүй хангана.

(1) Туршилт, лаборатор болон хичээлийн материалууд

(2) Номын сан, уншлагын заал, спорт төвүүд болон хичээл сургалтад шаардлагатай бусад газарт нэвтрэх

(3) Хичээл, сургалтын зорилготой орон нутгийн аялал

(4) Хүлээн авагч улсад хэрэглэгддэг хууль, тогтоомжийн дагуу сургалтын явцад практик дадлага хийхэд шаардлагатай тусгай тоног төхөөрөмж болон цэргийн хувцас. (Эдгээрийг сургууль төгссөний дараа буцааж өгнө.)

д. Сургалтын нислэг, сэтгэл судлалын сургалт, усанд шумбагчийн сургалт, чөлөөт шумбалтын цамхагийн сургалт болон бусад төрлийн өндөр өртөг шаарддаг сургалтуудын төлбөрийг бүтэн авна.

е. Турк Улс дахь турк хэлний сургалт болон Монгол Улс дахь монгол хэлний сургалт нь үнэ төлбөргүй байна.

ф. Хүлээн авагч улсын нутаг дэвсгэрээс гаднах бүх төрлийн тээврийн зардлыг илгээгч улс хариуцна.

г. Илгээгч улс нь сургалтыг хариу төлбөртэйг шийдэх ёстой ба, Илгээгч улс нь зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогчид олгосон сургалтын төлбөр болон бусад зардлыг сургалтын хугацаа, үйл ажиллагааны төгсгөлд нэхэмжлэл гаргаснаас хойш 60 /жар/ хоногийн дотор төлбөр хийх өдрийн хүчин төгөлдөр валютын ханшаар америк доллар, эсхүл еврогоор хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас тогтоосон банкны данс руу шилжүүлнэ.

2. Цэргийн солилцооны алба хаагчийн хувьд:

Илгээгч улс нь Цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийн санхүүгийн болон хувийн бүх төрлийн эрхийг хамгаалж, Илгээгч улс нь дор тодорхойлсон болон Солилцооны цэргийн бүх зардлыг хариуцна. Эдгээрээр мөн хязгаарлагдахгүй.



- (1) Сар бүрийн цалин, хуваарьт мөнгө болон тэтгэмж
- (2) Цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийн бүх тээврийн зардлыг хариуцна. Хүлээн авагч улс хүртэлх тээврийн зардал үүнд мөн хамаарна. (Гэр бүлийн гишүүдийн зардал нь Турк Улсын Цэргийн солилцооны хөтөлбөрийн хувийн хүлээх үүрэг хариуцлага байх ёстой.)
- (3) Цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийн хувийн эд хогшлийн тээвэрлэлт болон тэдгээрт учирсан алдагдал, хохирол (Гэр бүлийн гишүүдийн зардал нь Турк Улсын Цэргийн солилцооны хөтөлбөрийн хувийн хүлээх үүрэг хариуцлага байх ёстой.)
- (4) Цэргийн солилцооны алба хаагчийн энэхүү хэлэлцээрт тусгагдаагүй албан ёсны болон албан бус сургалтын зардал
- (5) Хугацаа нь дуусгавар болох буюу болсон цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийн буцахтай холбогдсон бүх зардал (Гэр бүлийн гишүүдийн зардал нь Турк Улсын Цэргийн солилцооны хөтөлбөрийн хувийн хүлээх үүрэг хариуцлага байх ёстой.)
- (6) Цэргийн солилцооны алба хаагчийн хэрэглэсэн цэргийн харилцаа холбооны хэрэгслээс гаднах харилцаа холбооны зардал (Гэр бүлийн гишүүдийн зардал нь Турк Улсын Цэргийн солилцооны хөтөлбөрийн хувийн хүлээх үүрэг хариуцлага байх ёстой.)
- (7) Цэргийн солилцооны алба хаагч нь өөрийн хувийн зардлыг өөрөө хариуцах ба Хүлээн авагч улс нь цэргийн солилцооны алба хаагчийн хувьд ямар нэгэн санхүүгийн хариуцлага хүлээхгүй.

13 дугаар зүйл

НЭМЭЛТ НӨХӨН ОЛГОВОР

1. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд хүн, эд хөрөнгө, байгаль орчин болон гуравдагч этгээдэд учирсан аливаа гарз, хохирлыг шийдвэрлэхэд хүлээн авагч улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.
2. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд гүйцэтгэх үйл ажиллагааны явцад эд хөрөнгө болон хүрээлэн буй орчинд учирсан гарз, хохирол, хүнд учирсан гэмтэл, амь насаа алдсан тохиолдлыг Талууд хамтран шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл

ЗАХИРГААНЫ АСУУДАЛ

1. Зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогчийн статус:
- а. Илгээгч улс нь энэхүү хэлэлцээрийн хүрээнд өөрийн алба хаагчид болон сонсогчдын статус, эрх үүрэг хариуцлага, сургалтын хүрээ, сургалтын байр хоолны нөхцөл байдал болон санхүүгийн асуудлын талаар мэдээлнэ.
- б. Зочин цэргийн алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүд болон зочин сонсогч нь дипломат дархан эрх ямба эдлэхгүй.



в. Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол хүлээн авагч улс нь зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогчийг энэхүү хэлэлцээр, эсхүл үүний дагуу байгуулагдах аливаа хэлэлцээ, тохиролцоонд тусгаснаас өөр үүрэг даалгаварт томилох ёсгүй.

г. Хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт үлдэхээр зөвшөөрөгдсөн Зочин цэргийн алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүн, түүнчлэн Зочин сонсогч нь аливаа улс төрийн үйл ажиллагаа болон Хүлээн авагч улсын эсрэг бусад үйл ажиллагаанд оролцохгүй.

д. Хүлээн авагч улс нь Зочин цэргийн алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүд (зөвхөн тэдний эхнэр/нөхөр, эсхүл 12-оос дээш насны хүүхэд) болон зочин сонсогчид тэдний статусын дагуу тусгай үнэмлэх олгоно.

2. Хувцас:

а. Цэргийн дунд сургууль, дайны академи болон ахлагчийн мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн сургуульд суралцах зочин сонсогч нь хүлээн авагч улсаас олгосон дүрэмт хувцсыг хэрэглэнэ.

б. Зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогч нь хүлээн авагч улсын анги, байгууллагад өөрсдийн зөвсэгт хүчний дүрэмт хувцсыг, сургалт, дадлагын явцад хүлээн авагч улсаас хангасан хувцсыг, анги, байгууллагаас гадуурх үйл ажиллагаанд энгийн хувцсыг тус тус өмсөнө.

3. Амралт, чөлөө:


а. Тэмдэглэлт баяр ёслол, амралт, чөлөө болон зочин цэргийн алба хаагч, зочин сонсогч эзгүй байх бусад тохиолдол зэргийг сургалтын төлөвлөгөө болон хүлээн авагч улсын адилтгах алба хаагчдад хэрэглэгддэг журмаар зохицуулна. Хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт оршин суугаа зочин цэргийн алба хаагч, зочин сонсогчийн сургалтын хугацаанд бусад зардлыг илгээгч улс хариуцна.

б. Зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогчийг хүлээн авагч улсын цэргийн эмнэлэгийн дүгнэлтийн дагуу өвчний учир чөлөөтэй байх зөвшөөрлийг үндэслэн сургалтын байгууллагаас тогтоосон хугацаагаар сургалтаас чөлөөлж болно. Өвчний учир чөлөөтэй байх хугацаа дуусах үед тухайн алба хаагч үүргээ үргэлжлүүлэх боломжгүй бол түүний үйл ажиллагааг дуусгавар болгох ба түүний оронд хүлээн авагч улсын зөвшөөрөлтэй өөр гишүүнийг томилно.

в. Талуудын эрх бүхий байгууллага хооронд байгуулагдсан тохиролцооны дагуу Хүлээн авагч улсын нутаг дэвсгэрийн гадна өнгөрөөснөөс бусад бүх чөлөөг Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага олгоно.

г. Зочин цэргийн алба хаагч болон зочин сонсогч нь хүлээн авагч улсын ажлын цаг болон тус улсад хэрэглэгддэг холбогдох дүрэм, журманд захирагдана.

д. Зочин цэргийн алба хаагч нь тэдгээрийн үндэсний тэмдэглэлт өдөр болон бусад өдрүүдэд тэдгээрийн цэргийн атташе болон Элчин сайдын яамны байранд зохион



байгуулагдах үйл ажиллагаанд оролцож болно. Энэ хугацаанд тэднийг чөлөөтэй байсанд тооцож болно.

4. Нас баралт:

а. Зочин цэргийн алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүд, зочин сонсогч нас барах тохиолдолд, хүлээн авагч улс нь нөхцөл байдлын талаар илгээгч улсын эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

б. Илгээгч улсын хүсэлтийн дагуу, хүлээн авагч улс нь нас барсан хүний цогцосыг өөрийн нутаг дэвсгэр дэх хамгийн ойролцоох нисэх онгоцны буудал, далайн боомт эсвэл хил рүү тээвэрлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй ба үүнтэй холбогдох бүх зардлыг гаргана. Дараа нь нас барсан хүний цогцосыг тээвэрлэх үүргийг Илгээгч улс хариуцна.

5. Хүлээн авагч улс нь зочин цэргийн алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүд, Зочин сонсогчийн аюулгүй байдал, орон байраар хангах болон бусад эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

15 дугаар зүйл ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1. Зочин сонсогчийн эмнэлэгийн шинжилгээ болон эмчилгээ үйлчилгээний зардлыг Хүлээн авагч улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу хариуцна. Хүлээн авагч улс нь Зочин сонсогчийн эрүүл мэндийн даатгалын төлбөр (хувийн эрүүл мэндийн даатгалаас бусад) болон эрүүл мэндийн төлбөрийг хариуцна.


2. Хүлээн авагч улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу худалдаж авах үндэсний эрүүл мэндийн даатгал, эсхүл олон улсын даатгалын хэлэлцээрийн дагуу хүчин төгөлдөр эрүүл мэндийн даатгалаар зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийн эмнэлэгийн шинжилгээ болон эмчилгээ үйлчилгээний зардлыг зохицуулна. Зочин цэргийн алба хаагч/цэргийн солилцооны алба хаагчийн даатгалын багцын төлбөр болон эмчилгээний төлбөрийг илгээгч улс хариуцна.

3. Эрүүл мэндийн даатгалгүй зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн шинжилгээ болон эмчилгээ үйлчилгээний зардлыг зочин цэргийн алба хаагч, эсхүл илгээгч улс хариуцна.

16 дугаар зүйл НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүд, түүнчлэн зочин сонсогч нь хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу оршин байгаа боломжинд тулгуурлан заал, хоолны газар, дэлгүүр болон цэргийн нийгмийн байгууламжийг ашиглаж болно.

1. Зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч болон зочин сонсогч нь өөрсдийн үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн газар (тусгай дуртгалын төвөөс бусад)



доторх болон хүлээн авагч улс тэдэнд өдөр тутам хэрэглэхийгзөвшөөрсөн нийгмийн байгууламжийг ашиглана.

2. Зочин цэргийн алба хаагч, цэргийн солилцооны алба хаагч болон зочин сонсогч нь өдөр бүр, эсхүл одоогийн хууль тогтоомж болон тогтоосон үнийн жагсаалтын дагуу хүлээн авагч улсын зөвшөөрлөөр орон сууцны зориулалтаар бусад цэргийн хуаран дахь нийгмийн байгууламжуудыг ашиглаж болно.

3. Зочин цэргийн алба хаагч, Цэргийн солилцооны алба хаагч болон Зочин сонсогч нь ангийн захирагчийн зөвшөөрлөөр сургалтад хамрагдах эсвэл үүрэг гүйцэтгэхээр томилогдсон цэргийн анги, штаб болон байгууллага доторх гуанз, хоолны газар зэрэг бусад байгууламжийг ашиглана.

17 дугаар зүйл ГААЛЬ БОЛОН ХИЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ

1. Зочин цэргийн алба хаагч, Цэргийн солилцооны алба хаагч болон тэдний гэр бүлийн гишүүн, түүнчлэн зочин сонсогч нь тухайн улс дахь гадаадын иргэдийн аялал, нэвтрэн орох, гарахад хэрэглэгддэг хүлээн авагч улсын гаалийн бүрдүүлэлтийн талаарх Хүлээн авагч улсын хууль тогтоомжийг мөрдөнө.

2. Гэхдээ хүлээн авагч улс нь хууль тогтоомжийн дагуу боломжит захиргааны дэмжлэг үзүүлнэ.


18 дугаар зүйл МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

1. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх болон тайлбарлахад үүсч болох аливаа маргааныг гуравдагч улс, байгууллага руу шилжүүлэлгүйгээр Талууд хоорондын зөвшилцөл, хэлэлцээрээр шийдвэрлэнэ.

2. Хэрэв маргаан нь хэлэлцээ эхэлснээс хойш 90 /ер/ хоногийн дотор шийдвэрлэгдээгүй бол, Талууд нь энэхүү хэлэлцээрийг 30 /гуч/ хоногийн урьдчилсан бичгээр гаргасан мэдэгдлээр дуусгавар болгож болно.

19 дүгээр зүйл НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ БОЛОН ХЯНАН ҮЗЭХ

1. Шаардлагатай тохиолдолд Талуудын аль нэг нь бичгээр гаргасан мэдэгдлээр, дипломат шугамаар энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах болон дахин хянан үзэхээр санал гаргаж болно. Хэлэлцээ нь бичгээр гаргасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 /гуч/ хоногийн дотор эхэлнэ. Хэрэв 60 /гуч/ хоногийн дотор ямар нэгэн үр дүнд хүрээгүй бол Талуудын аль аль нь 90 /ер/ хоногийн бичгээр гаргасан мэдэгдлээр энэхүү Хэлэлцээрийг дуусгавар болгож болно. Харилцан тохиролцсон



нэмэлт, өөрчлөлт нь энэхүү хэлэлцээрийн хүчин төгөлдөр болох байдлыг тогтоосон энэхүү хэлэлцээрийн 20 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу хүчин төгөлдөр болно.

20 дугаар зүйл СОЁРХОН БАТЛАХ БОЛОН ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

1. Энэхүү хэлэлцээр нь Талууд түүнийг хүчин төгөлдөр болгоход тавигддаг дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн тухай сүүлчийн мэдэгдлийг дипломат шугамаар хүлээн авсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

2. 1999 оны 12 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан "Бүгд Найрамдах Турк Улсын Жанжин Штаб болон Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин Штаб хоорондын цэргийн сургалтын хамтын ажиллагааны тухай Хэлэлцээр", 2009 оны 10 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан "Бүгд Найрамдах Турк Улсын Жанжин Штаб болон Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин Штаб хоорондын цэргийн сургалтын хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн 1 дүгээр нэмэлт протокол"-ууд тус тус дуусгавар болно. Гэвч, энэхүү хэлэлцээрийн дагуу хийгдсэн нэмэлт, өөрчлөлт, протокол болон үйл ажиллагаа нь үргэлжлүүлэн хэрэглэгдэнэ.

21 дүгээр зүйл ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОН ДУУСГАВАР БОЛОХ ХУГАЦАА

1. Энэхүү хэлэлцээр нь 5 /тав/ жил хүчин төгөлдөр байна. Талуудын нэг нь нөгөө талдаа энэхүү хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдал дуусгавар болохоос өмнөх 90 /ер/ хоногт энэхүү хэлэлцээрийг дуусгавар болгох хүсэлтээ бичгээр мэдэгдснээс бусад тохиолдолд энэхүү хэлэлцээр жил бүр 1 /нэг/ жилээр сунгагдана. "Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын цэргийн салбар дахь хамтын ажиллагааны тухай хэлэлцээр" дуусгавар болсон тохиолдолд энэхүү хэлэлцээр дуусгавар болно.

2. Хэрэв Талуудын нэг нь нөгөө Тал хэлэлцээрийн заалтыг дагахгүй, эсхүл дагаж чадахгүй байгаа гэж үзсэн тохиолдолд, хэлэлцээ хийхээр бичгээр санал гаргаж болно. Хэлэлцээ нь урьдчилсан бичгээр гаргасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 /гуч/ хоногийн дотор эхэлнэ. Дараагийн 60 /жар/ хоногийн дотор ямар нэгэн үр дүнд хүрээгүй бол Талуудын аль нь ч энэхүү хэлэлцээрийг 90 /ер/ хоногийн бичгээр гаргасан мэдэгдлээр дуусгавар болгож болно.

3. Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэхүү Хэлэлцээрийг дуусгавар болгох нь хэрэгжиж буй хөтөлбөр, үйл ажиллагаанд нөлөөлөхгүй.

22 дугаар зүйл ЭХ БИЧВЭР БОЛОН ГАРЫН ҮСЭГ



Энэхүү хэлэлцээрийг турк, монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр нь адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлах явцад зөрүү гарвал, англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

Дээр дурдсаныг нотолж, гарын үсэг зурагч нь тус тусын Засгийн газраас зохих ёсоор эрх олгогдож энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

**БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг:

Нэр : Исмет ИЛМАЗ

Цол: —

Албан тушаал: Үндэсний Батлан
хамгаалахын сайд

Огноо: 16.12.2015

Хаана: Анкара хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг:



Нэр : Цэрэндашийн ЦОЛМОН

Цол: 2



Албан тушаал: Батлан хамгаалахын
сайд

Огноо: 2015.12.09

Хаана: Улаанбаатар хот



AGREEMENT
BETWEEN
THE GOVERNMENT OF THE REPUBLIC OF
TURKEY
AND
THE GOVERNMENT OF MONGOLIA
ON
MILITARY TRAINING COOPERATION



AGREEMENT BETWEEN THE GOVERNMENT OF THE REPUBLIC OF TURKEY AND THE GOVERNMENT OF MONGOLIA ON MILITARY TRAINING COOPERATION

PREAMBLE

The Government of the Republic of Turkey and the Government of Mongolia (Hereinafter referred to as the "Party" or the "Parties");

Based on the "Agreement on Cooperation in Military Field signed between the Government of the Republic of Turkey and the Government of Mongolia", on December 02, 1999.

Emphasizing their desire to improve the friendly relations existing between the Parties and the cooperation in military training field,

Have agreed upon the following matters:

ARTICLE I

PURPOSE

This Agreement aims to establish mechanisms for cooperation between the Parties in military training field.

ARTICLE II

FIELD OF IMPLEMENTATION


The provisions provided for in this Agreement are applied to the officers, NCOs (non-commissioned officer), specialized sergeants, contracted rank and files, rank and files, cadets and civilian personnel of the Armed Forces of one of the Parties who are accepted to receive training in the military training institutions, units and military facilities of the other Party or involved in the conduct of training and cooperation activities as well as their dependents in accordance with Article IV of this Agreement.

ARTICLE III

DEFINITIONS

The terms laid down in this Agreement shall have the following meanings:

1. **Agreement** means the Military Training Cooperation Agreement concluded between the Parties.
2. **Sending State** means the Party sending personnel, material or equipment to the Receiving State for the implementation of this Agreement.
3. **Receiving State** means the Party hosting the personnel, material and equipment of the Sending State in its territory for the implementation of this Agreement.
4. **Competent Authority** means the competent authorities of the Parties relating to the implementation of this Agreement are as follows:
 1. For the Government of the Republic of Turkey: General Staff of the Republic of Turkey,
 2. For the Government of Mongolia: Ministry of Defence.
5. **Guest Military Personnel** means the military or civilian personnel that the Parties have in the territory of the other Party within the framework of the implementation of this Agreement as trainee, trainer, instructor, advisor, observer, etc.
6. **Dependents** means the accompanying spouses and children of the Guest Military Personnel within the scope of this Agreement for whom they are responsible looking after according to their respective national legislation.
7. **Commander** means the person who is commanding the military headquarters, military base or military unit and who is responsible for the activities of the military personnel sent to be subordinate to him/her.



8. **Senior Military Personnel** means the most senior staff member among the military personnel authorized to supervise the activities of the military/civilian group sent within the scope of this Agreement and appointed in accordance with the national legislation of the Sending State.
9. **Guest Cadet** means a staff member who is sent to the military academies, military faculty of medicine, military high schools and NCO vocational higher-education schools to be assigned by the Sending State as a military officer or an NCO and who has not achieved the status of an officer or NCO yet.
